



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хубилай давхар даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Алдагдлаас хамгаалах сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох журмын дагуу бүрэн байршуулж, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Хубилай давхар даатгал” ХХК /Б.Жавхлантай/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12 сарын 04 өдрийн
548-р тогтоолын хавсралт



“ХУВИЛАЙ ДАВХАР ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭДЛЭХҮҮН

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл		Өөрчлөлт		Эцсийн үлдэгдэл	
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хоролдон
1	Х.Хандсүрэн /ЧТ75122964/	82,775,000	82,775,000.00	55%	67,725,000	6,772,500,000.00	150,500,000
2	Б.Нямсүрэн /ИВ77101606/	37,625,000	37,625,000.00	25%	(37,625,000)	3,762,500,000.00	150,500,000
3	Ж.Мөнхбаяр	30,100,000	3,010,000,000.00	20%	(30,100,000)	3,010,000,000.00	15,050,000,000.00
Нийт		150,500,000	15,050,000,000.00	100%	6,772,500,000.00	6,772,500,000.00	15,050,000,000.00